



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулах
үйл ажиллагааны удирдамж батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.16, 5.11 дэх заалтууд, ШУТИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/160 дугаар “Шинээр байгуулагдсан тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалт явуулах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан удирдамжийг үйл ажиллагаанд баримтлан, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахыг “Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс”-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Б.ТУНГАЛАГТАМИР



367740069

ШУТИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН
ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Математикийн тэнхимийн эрхлэгч, Физикийн тэнхимийн эрхлэгч, Химийн инженерчлэлийн тэнхимийн эрхлэгч, Биеийн тамир, спортын тэнхимийн эрхлэгчийг тус тус сонгон шалгаруулхтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү удирдамжийг баримтална.
- 1.2. Тэнхимийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа хүний эрх, нэр төр, мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, тэгш хандах, хууль тогтоомж, шударга ёсыг дээдлэх, нууцыг хадгалах, нээлттэй ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтална.
- 1.3. ШУТИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан “Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах комисс” нь удирдамжийн дагуу сонгон шалгаруулалтыг явуулж, үр дүнгийн тайлан, холбогдох материалыг Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
- 1.4. Сонгон шалгаруулалтын комисс нарийн бичгийн даргаар нэг гишүүнийг сонгон ажиллуулна.
- 1.5. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгч нарыг сонгон шалгаруулах зарыг ШУТИС-ийн албан ёсны веб хуудас, бүрэлдэхүүн сургуулийн веб хуудас, сошиал сувгууд ашиглан нийтэд хүргэнэ.

Хоёр. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчид тавих шаардлага

- 2.1. Сонгон шалгаруулалтад оролцогч зөвхөн нэг тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвших эрхтэй.
- 2.2. Дараах шалгуур, шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн нь тэнхимийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтад нэр дэвших эрхтэй. Үүнд:
 - 2.2.1. Доктор (Ph.D)-с доошгүй эрдмийн зэрэгтэй;
 - 2.2.2. Тухайн тэнхимийн сургалт, судалгааны аль нэг чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;
 - 2.2.3. Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан;
 - 2.2.4. Багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дадлага, туршлагатай;
 - 2.2.5. Мэргэжлийн чиглэлээр салбартаа нэр хүндтэй, хариуцсан нэгжийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэх чадвартай;

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх

3.1 Нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- 3.1.1. Сонгон шалгаруулалтад оролцогчийн гараар бичсэн хүсэлт;
- 3.1.2. Төрийн албан хаагчийн анкет, зурагтай (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолоор баталсан анкет);
- 3.1.3. Иргэний үнэмлэхийн хуулбар (E-mongolia системээс авсан лавлагаа);

ХШУС-ийн захирлын 2025.05.19.-ны
05 дугаар сарын 19.-ны өдрийн
1/10 дугаар тушаалын хавсралт
СҮРГҮҮЛЬ

- 3.1.4. Боловсролын түвшин, эрдмийн зэрэг, цолыг тодорхойлсон баримт бичиг (хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах)-ийн хуулбар;
- 3.1.5. Ажлын туршлагын шаардлагыг хангасан тухай нотлох баримт (нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр, албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал шийдвэр г.м.)-ийн хуулбар, лавлагаа;
- 3.1.6. Бүтээлийн жагсаалт;
- 3.1.7. Тэнхимийг хөгжүүлэх мөрийн хөтөлбөр. Мөрийн хөтөлбөр нь дараах агуулгатай байна. Үүнд:
- 3.1.7.1. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 13 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-ний стратегийн үндсэн зорилт, чиглэлийн хүрээнд тухайн Тэнхимд хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
- 3.1.7.2. Тэнхимийн хэрэгжүүлдэг сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, сургалтын чанар, материаллаг баазыг дээшлүүлэх, хөтөлбөр хөгжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
- 3.1.7.3. Тэнхимийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, нийгмийн түншлэл, мэргэжлийн үйлчилгээ болон оюутны үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажил, тэдгээрийн хүлээгдэж буй үр дүн;
- 3.1.7.4. Тухайн тэнхимийн хөгжлийг хангахад чиглэсэн өөрийн санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажил, төсөл, хөтөлбөр;
- 3.1.7.5. Хөтөлбөрийг 3 жилээр боловсруулсан байна.

Тайлбар: Бүрдүүлсэн баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан байхыг шаардахгүй бөгөөд баримт бичгийн үнэн зөвийг хүсэлт гаргасан иргэн өөрөө бүрэн хариуцна.

- 3.2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэн бүрдүүлсэн баримт бичгийг дугтуйнд хийж битүүмжлэн ШУТИС-ийн хичээлийн 1 дүгээр байрны 410 тоот өрөөнд (Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн захирлын туслах) өөрийн биеэр хүлээлгэн өгнө.


Хүлээн авах хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 20-ны 09:00 цагаас 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цаг хүртэлХолбоо барих утас: 11-322283-2301 (Ажлын цагаар)

- 3.3. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигчдийн ирүүлсэн материалтай танилцаж, нэр дэвшигч тус бүрээр материалын бүрдэл хангасан эсэх, нэр дэвшигч нь тавигдсан шалгуур шаардлагыг хангаж байгаа эсэх, боловсруулсан мөрийн хөтөлбөр нь 3.1.7 заалтад дурдсан агуулгатай нийцэж байгаа эсэхийг нягтална.

- 3.4. Нэр дэвшигч нь заагдсан шалгуур, шаардлагыг хангаагүй, бичиг баримтын бүрдэл дутуу бол тухайн нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

Дөрөв. Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, шийдвэр гаргалт

- 4.1. Сонгон шалгаруулалтын комисс үйл ажиллагааны хуваарийн дагуу нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцана.
- 4.2. Тэнхимийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичиг нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага болон бусад тавигдсан нөхцөлийг хангасан эсэхийг Сонгон шалгаруулалтын комисс нэг бүрчлэн шалгаж, баримтыг



дтуу бүрдүүлсэн болон тавигдах шаардлага хангасан нэг чиглэлд нийцэж буй эсэхийг комисс тогтооно.)

- 4.3. Материалын бүрдэл нь шаардлага хангасан нэг чиглэгийн 2025 оны 05 дугаар сарын 27-29-ны өдрүүдийн аль нэгэнд харгалзуулан гаргасан хуваарийн дагуу мөрийн хөтөлбөрөө Сонгон шалгаруулалтын комисс болон тухайн нэг чиглэлд нийцэж буй эсэхийг комисс тогтооно.)
- 4.4. Сонгон шалгаруулалтын комисс 35 хүртэл оноо, тэнхимиин хамт олон 65 хүртэл оноогоор нэг чиглэгийн үнэлнэ. Үнэлгээний аргачлал, маягтыг Сонгон шалгаруулалтын комисс боловсруулна.
- 4.5. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн танилцуулга хурлын бэлтгэл ажлыг захирлын туслах, тухайн тэнхимд харьялагдах нэр дэвшээгүй зарим багш, сургалтын мастерууд хамтран хариуцна. Хурлын тэмдэглэлийг тухайн тэнхимиийн сургалтын мастер хөтөлнө.
- 4.6. Сонгон шалгаруулалтын комиссын дарга хурлын дэгийг тогтоон, хурлыг удирдана.
- 4.7. Хурлын тэгсгэлд нэр дэвшигчид өгөх үнэлгээг хамт олоос нууц санал хураалтаар авна. Санал өгөх тэнхимиийн хамт олны багш, ажилтны нэрсийн жагсаалтыг нарийвчлан гаргаж, баталгаажуулсан саналын хуудсаар санал авна. Зөвхөн хуралд биечлэн ирсэн багш, ажилтан санал өгөх эрхтэй бөгөөд түр чөлөөтэй байгаа багш, ажилтан биечлэн ирж саналын эрхтэй оролцож боломжтой.
- 4.8. Тэнхимиийн хамт олны 2 төлөөлөл болон Сонгон шалгаруулалтын комиссын нарийн бичгийн дарга нууц санал хураалтыг тоолж, нэр дэвшигч бүрээр гаргана.
- 4.9. Сонгон шалгаруулалтын комиссын гишүүдийн саналыг комиссын дарга нэгтгэнэ.
- 4.10. Сонгон шалгаруулалтын комисс нэр дэвшигч бүрээр нийт оноог нэгтгэн эрэмбэлж, тэнхимиийн хамт олонд танилцуулна.
- 4.11. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дусахад Сонгон шалгаруулалтын комисс нь сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны тайлан, хурлын тэмдэглэл, шалгарсан нэр дэвшигчийн холбогдох материалууд, нэр дэвшигчдийн саналын хуудсууд болон бусад баримт бичгийг нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 02-ны дотор ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлнэ.
- 4.12. Сонгон шалгаруулалтад ороогүй хүний материалыг тухайн тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалд нэр дэвшүүлэхээр Захиргааны удирдлагын газарт хүргүүлэхийг хориглоно.
- 4.13. ШУТИС-ийн Захиргааны удирдлагын газар хүргүүлсэн материалыг нэгтгэн, үр дүнг ШУТИС-ийн Ректорт танилцуулснаар Ректор тэнхимиийн эрхлэгчдийг томилно. Шаардлагатай тохиолдолд Сонгон шалгаруулалтын комисс, нэр дэвшигчээс нэмэлт мэдээлэл, тодруулга өгнө.
- 4.14. Хэрэв сонгон шалгаруулалтад оролцоо нэг ч иргэн материал ирүүлээгүй бол Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн захирал тухайн тэнхимиийн эрхлэгчийн албан тушаалын шаардлага хангасан нэр дэвшигчдийг Ректорт санал болгоно. Ректор санал болгосон нэр дэвшигчдийн холбогдох материалтай танилцаж, ярилцлага хийсний үндсэн дээр сонгож, сонгогдсон нэр дэвшигчийг тэнхимиийн эрхлэгчээр томилно.
- 4.15. Сонгон шалгаруулалттай холбогдон гарсан гомдол, хүсэлтийг Сонгон шалгаруулалтын комиссоос холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, хариуг өгнө.